Tax and Legal alert

Mongolia • Issue 4/2018 • 18 June 2018

New requirements are imposed on legal and business consultants under amendments to the Law on Combating Money Laundering and Terrorism Financing

Contacts:

Michael Ahern
Partner , Tax and Legal Services
michael.ahern@pwc.com

Tsendmaa Choijamts
Executive Director, Tax and Legal Services
tsendmaa.choijamts@pwc.com

Maryna Tarnavska
Senior Manager, Tax and Legal Services
tarnavska.maryna@pwc.com

Munkhjargal Ragchaakhuu
Senior Legal Consultant
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

PwC Tax TMZ LLC
Central Tower 6th floor.
Suite 603, Ulaanbaatar
14200, Mongolia
Tel : + 976 70009089
Fax : +976 11 322068
www.pwc.com/mn

The Parliament of Mongolia amended the Law on Combating Money Laundering and Terrorism Financing (Law on AML/TF) on 26 April 2018. Under these amendments, legal and business consulting service providers are obliged to undertake a client identification procedure and to report transactions exceeding a certain threshold to the Financial Intelligence Unit of Bank of Mongolia.

Generally, banking and financial institutions are required to report on transactions above MNT 20 million to the Financial Intelligence Unit within 5 days after occurrence of such transactions.

However, the recent amendments broadened the scope of the **reporting entities**, where **legal and/or business consultancy service providers** which undertake the following transactions on its client's behalf (with a certain threshold) are also included.

1. Sale and purchase of immovable properties
2. Establishment of legal entities, management of operation, transactions of the client or sale of legal entities
3. Management of client's assets
4. Organization of a fund-raising for establishment of a company and its operations
5. Management of bank accounts, deposit or securities of the client

Reporting entities (including but not limited to legal and business consultants):

1. shall identify clients, their beneficial owners and nature of the transactions prior to rendering services;
2. are prohibited to render services in case the client has refused to provide necessary information/documents;
3. are obliged to approve their own internal monitoring and risk management policy and register it with the respective license-issuing authorities.

This Alert is produced by PwC Tax TMZ LLC. The material contained in this alert is provided for general information purposes only and does not contain a comprehensive analysis of each item described. Before taking (or not taking) any action, readers should seek professional advice specific to their situation. No liability is accepted for acts or omissions taken in reliance upon the contents of this alert.

© 2018 PricewaterhouseCoopers Tax TMZ LLC.
All rights reserved. In this document, "PwC" refers to PricewaterhouseCoopers Tax TMZ LLC, which is a member firm of PricewaterhouseCoopers International Limited, each member firm of which is a separate legal entity.

pwc

Beneficial ownership

The amendment changed the definition of the beneficial owners and relevant provisions in several other laws.

As you may be aware of, we issued Tax and Legal Alerts on the concept and registration requirements for "ultimate holders" of legal entities, which maintain mining licenses, land use and/or possession rights for tax purposes in January and May 2018.

Due to amendments to the Law on AML/TF , the definition of the beneficial owner under this law has became applicable for determining ultimate holders of the aforesaid legal entities to disclose the information to the tax authorities.

We expect that companies which have already disclosed their ultimate holders based on the definitions that served prior to the amendments to the Law on AML/TF would need to revise their disclosed information in order to comply with the new definition of beneficial owners.

Penalties

Non compliance with the various requirements by the reporting entities shall be subject to fines up to MNT 200 million, ceasing of income earned, confiscations of licenses or demanding resignation of the management of a reporting entity depending on the non-compliance nature.

Implementation

Amendments to the Law on AML/TF will take effect from 1 July 2018. The reporting entities are given a grace period of 2 months to comply with the new requirements.

pwc

ТАТВАР БОЛОН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол улс • Дугаар 4/2018 • 2018 оны 6 сарын 18-ны өдөр

Хууль, санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд нэмэлт үүрэг хүлээдэг боллоо

Монгол Улсын Их Хурал (“УИХ”)-аас 2018 оны 4 сарын 26-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (“МУТСТХ”)-д нэмэлт, өөрчлөлт оруулсан. Уг нэмэлт өөрчлөлтөөр хууль болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч этгээдүүд нь харилцагчийг таньж мэдэх ажиллагаа явуулах болон тодорхой үнийн дүн бүхий хэлцлийн талаар Монголбанкны Санхүүгийн Мэдээллийн Албанд мэдээлэх үүрэг хүлээхээр боллоо.

МУТСТХ-аар банк, санхүүгийн байгууллагуудыг 20 сая төгрөг түүнээс дээш үнийн дүн бүхий гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор Санхүүгийн Мэдээллийн Албанд мэдээлэхийг шаарддаг байсан.

Харин МУТСТХ-д орсон нэмэлт өөрчлөлтийн хүрээнд дээрх **мэдээлэх үүрэг бүхий этгээдийн** хүрээг өргөжүүлж, **хууль болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч** этгээдүүд нь дор дурдсан үйл ажиллагааг харилцагчийн нэрийн өмнөөс гүйцэтгэсэн бөгөөд тодорхой үнийн дүнгээс дээш хэлцлийг мэдээлэх үүрэгтэй болсон. Үүнд:

1. Үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах
2. Хуулийн этгээд үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг удирдах эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллаагаа явуулах, удирдах, эсхүл хуулийн этгээдийг худалдах, худалдах
3. Харилцагчийн хөрөнгийг удирдах
4. Компани үүсгэн байгуулах, үйл ажиллагааг удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах
5. Банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах

Мэдээлэх үүрэг бүхий этгээдүүд (хууль, санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдийг оролцуулан):

1. үйлчилгээ үзүүлэхээс өмнө харилцагчийг таньж мэдэх ажиллагааг тодорхой журмын дагуу заавал хийх ёстой бөгөөд харилцагчийн эцсийн өмчлөгч болон хэлцлийн мөн чанарыг тогтоох ёстой;
2. хэрэв харилцагч хуульд заасан шаардлагатай мэдээллийг өгөхөөс татгалзсан тохиолдолд мэдээлэх үүрэг бүхий этгээд нь үйлчилгээ үзүүлэхгүй байх үүрэгтэй;
3. дотоод хяналтын болон эрсдлийн удирдлагын хөтөлбөрийг баталж, тусгай зөвшөөрөл олгосон байгууллагадаа бүртгүүлж, хэрэгжүүлэн ажиллах үүрэгтэй.

Холбогдох хаяг:

Майк Ахэрн
Партнер, Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
michael.ahern@kz.pwc.com

Чойжамцын Цэндмаа
Гүйцэтгэх захирал, Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@mn.pwc.com

Марина Тарнавска
Ахлах Менежер, Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tarnavska.maryna@mn.pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал
Хуулийн Ахлах Зөвлөх
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК
Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот , Улаанбаатар
14200, Монгол Улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068

www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2018 PricewaterhouseCoopers Tax TMZ LLC.
All rights reserved. In this document, “PwC” refers to PricewaterhouseCoopers Tax TMZ LLC, which is a member firm of PricewaterhouseCoopers International Limited, each member firm of which is a separate legal entity.

pwc

ТАТВАР БОЛОН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол улс • Дугаар 4/2018 • 2018 оны 6 сарын 18-ны өдөр

Эцсийн өмчлөгч
Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр эцсийн өмчлөгч гэсэн тодорхойлолтыг шинэчлэн найруулсан бөгөөд бусад хуулиуд дахь холбогдох заалтуудыг мөн өөрчилсөн байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эсхүл газар эзэмших эрх эсхүл газар ашиглах эрхтэй хуулийн этгээдийн “эцсийн эзэмшигч”-ийн талаарх шинэ зохицуулалт, бүртгэлийн шаардлагыг тодруулсан мэдээллийг бид 2018 оны 1 болон 5 дүгээр саруудад хүргэж байсан.

Харин МУТСТХ-д орсон нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсноор уг хуульд заасан эцсийн өмчлөгчийн тодорхойлолт нь дээр дурдсан эрх эзэмшигч хуулийн этгээдээс эцсийн эзэмшигчээ татварын зорилгоор тодорхойлоход мөн ашиглагдахаар болж байна.

Бидний харж байгаагаар, энэ хууль батлагдахаас өмнө үйлчилж байсан тодорхойлолтын дагуу эцсийн эзэмшигчээ тодорхойлж, зохих байгууллагуудад бүртгүүлсэн компаниудын тухайд эцсийн эзэмшигчээ шинэ тодорхойлолтод нийцүүлэн дахин шинэчлэн тодорхойлж, бүртгүүлэх шаардлага гарах магадлалтай байна.

Хүлээлгэх хариуцлага
Мэдээлэх үүрэг бүхий этгээдүүд (хууль, санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдийг оролцуулан) нь хуулиар хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд зөрчлийн шинж чанараас шалтгаалан хуулийн этгээдийг 200 сая хүртэлх төгрөгөөр торгох болон/эсхүл олсон орлогыг хураах, эсхүл тусгай зөвшөөрлийг цуцлуулах хүсэлтийг харьяалах тусгай зөвшөөрөл олгогчид хүргүүлэх эсхүл тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтныг ажлаас нь чөлөөлөх, түдгэлзүүлэх, өөрчлөхийг үүрэг болгох зэрэг арга хэмжээ авах, хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

Хэрэгжилт
МУТСТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль нь 2018 оны 7 сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөнө. Харин харилцагчийг таньж мэдэх зохицуулалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан мэдээлэх үүрэгтэй этгээд нь хоёр сарын хугацаанд шаардлагатай арга хэмжээ авах ёстой болж байна.

pwc